



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ

9
АНГИ

ГАЗАР ЗҮЙ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

САНАМЖ


- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

1. Байр зүйн зурагт гуу жалгыг дүрслэхэд аль таних тэмдэг тохиромжтой вэ?



2. Хөвсгөл нуурыг Google Earth-ээс авсан зураг аль нь байна вэ?




3. Сар ямар хэлбэртэй харагдах байдлаар нь билгийн тооллыг тооцдог. Шинийн 15-ны өдөр сар ямар хэлбэртэй харагдахыг сонгоорой.




4. Монгол орны 2021 оны хүн амын суваргыг ажиглан хамгийн их хувийг хэдээс хэдэн насны, ямар хүйсийн хүмүүс эзэлж байна вэ?

2021



■ Эрэгтэй ■ Эмэгтэй

5. Монгол улсад хэдэн оноос хотын хүн ам нь хөдөөгийн эзлэх хувиас давсан байна вэ?



- A. 1970 B. 1980 C. 1990 D. 2000

6. Хотыг дотор нь хүн амын тоо, эдийн засагт гүйцэтгэж буй үүргээс нь хамааруулан улсын болон аймгийн зэрэглэлд ангилдаг. Доорх хотуудаас улсын зэрэглэлд хамаарах хотыг сонгоно уу.

- A. Дархан B. Цэцэрлэг C. Сайншанд D. Мөрөн


7. Байгалийн нөөцийн нөхөн сэргээгдэх нөөцдөд хамааралтайг нь сонгоорой?

- A. Газрын тос, нүүрс B. Зэс, молибден
C. Гол мөрөн, нуур D. Хайлуур жонш

8. Нүүрс нь газрын гадаргаас хэр гүнд оршиж байгаагаас хамааран ил ба далд уурхайн олборлолт хийдэг. Нүүрсний ил болон далд уурхайн олборлолтын гол ялгаа аль нь вэ?


- A. Ил уурхай нь хөрс хуулж олборлодог, далд уурхай нь гүнээс олборлодог
B. Ил уурхай нь гадаргаас шууд тээвэрлэдэг, далд уурхай нь хөрсийг хуулдаг
C. Ил уурхай нь гүнээс олборлодог, далд уурхай нь хөрс хуулж олборлодог
D. Ил уурхай нь жижиг хэсгийг олборлодог, далд уурхай нь том хэсгийг олборлодог

9. Зургийг ажиглан 2005 – 2016 оны ямаан сүргийн бүтцийн өөрчлөлт байгаль орчинд хэрхэн нөлөөлсөн байгааг тайлбарлаарай.



- A. Ямааны тоо толгой буурахад усан хангамж нэмэгдэж, уур амьсгал өөрчлөгдсөн
B. Ямааны тоо толгой өсөж усан хангамж бууран, ургамлын гарц бацассан
C. Ямааны тоо толгой буурч агаарын чийг нэмэгдэн, хөрсний үржил шим нэмэгдсэн
D. Ямааны тоо толгой буурч дулаан хангамж нэмэгдэн ургамлын гарц сайжирсан

10. Монгол орны газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэлтийн зургаас ХАНГАЙН бүсийн гол аймгийг сонгоорой.



11. Аж үйлдвэрийн салбарын байршилд нөлөөлөх хүчин зүйлсийн зургийг ажиглаад асуултад хариулаарай. Аж үйлдвэрийн байршилд хамгийн чухал нөлөө үзүүлэх хүчин зүйлийг сонгоорой.


**Аж үйлдвэрийн
салбарын байршилд
нөлөөлөх хүчин зүйл**

- 
- A. Байгалийн нөхцөл
 - B. Хөдөлмөрийн нөөц
 - C. Дэд бүтэц
 - D. Байгалийн нөөц, түүхий эд

12. Усалгаатай газар тариалан эрхлэх нь ямар давуу талтай вэ?

- A. Зэрлэг ургамлын ургалт ихсэж, талбай дахь тариалалтын гарцад ихээр нөлөөлнө.
- B. Их хэмжээний ус зарцуулах учир хөрсний эвдрэлд орж тариалалт багасна.
- C. Усжуулалтын системийн өртөг их тариалангийн үйл явцын ашиг шим хангалтгүй.
- D. Бүх төрлийн үр тариа, хүнсний ногоог хаана ч тариалан усжуулах бүрэн боломжтой.

13. Зургийг ажиглан агаарын тээврийн төрөлд хамаарах тээврийн хэрэгслийг ялган нэрлээрэй.



- A. 1,5,10
- B. 3, 6, 14
- C. 9, 11, 12
- D. 4, 8, 15

14. Ковид-19 цар тахлаас үүдэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор хот доторх болон хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг 2020 оны 11 сараас 2021 оны 6 сарыг дуустал хязгаарлаж байсан нь зорчигчдын тоо огцом буурахад нөлөөлсөн. Хамгийн **их** зорчигч тээвэр буурсан тээврийн төрлийг сонгоорой.


Тээврийн төрөл	2017 он /сая хүн/	2018 он /сая хүн/	2019 он /сая хүн/	2020 он /сая хүн/	2021 он /сая хүн/	2021/2020
Төмөр зам	2.6	2.6	2.9	2.0	0.4	80%
Авто зам	212.2	193.0	168.4	124.1	106.5	14.2%
Усан зам	0.0	0.0	0.0	-	0.02	-
Агаар	1.3	1.4	1.6	0.4	0.2	50%
Нийт	216.1	197.0	173.0	126.5	107.1	15.3%

- A. Төмөр зам
- B. Авто зам
- C. Усан зам
- D. Агаарын зам

15. Аялал жуулчлалын эдийн засагт үзүүлэх эзэрэг үр дагаврыг сонгоорой.

- A. Дулааны улиралд л ашигтай.
- B. Газрын үнэ өснө.
- C. Иргэдийн орлого өснө.
- D. Хог хаягдал нэмэгдэнэ.

16. Зургаас харахад Хөлөнбуйр-Булган сумын аялал жуулчлалын бүсэд ямар төрлийн аялал зохион байгуулахад тохиромжтой байна вэ?




- A. Авто машинаар – Шувуу агнах
C. Явганаар – Ууланд алхах
- B. Мориор – Шувуу ажиглах
D. Завиар – Нууртай танилцах

17. Монгол Улсын 2020 оны эхний хагас жилийн шуудан илгээмжийн урсгалыг харуулсан мэдээллийг ашиглан нийт шуудан, илгээмжээс хэдэн хувь нь дотоодынх байгааг тооцоолж олоорой.




- A. 0.95 %
B. 1.77 %
C. 2.7 %
D. 96.3 %

18. Зурагт өгөгдсөн эдийн засгийн бүсийн зургийг ажиглан тулгуур хотыг сонгоорой.





- A. Эрдэнэт, Мандалговь
B. Дархан, Зуунмод
C. Сайншанд, Сүхбаатар
D. Даланзадгад, Чойр


19. Доорх зураг дахь нарны тусгалын өнцөг ямар улирлынх болохыг тодорхойлоорой.
Монголчууд энэ үед ямар үйл ажиллагааг явуулахад тохиромжтой вэ?



- A. Зуны улирал, нарны эрчим хүчийг хуримтлуулж цахилгаан, дулаан үйлдвэрлэх
B. Хаврын улирал, урин дулаан болж тария ногоогоо тарин, боловсруулах
C. Намрын улирал, тария ногоогоо хурааж, эх малын хээл авхуулах
D. Өвлийн улирал, өвлийн идшээ бэлтгэхдээ давхар борц хийж хатааж бэлтгэх
20. 2021 оны байдлаар Монгол Улсын нийт нутагт 18.3 сая хүн хангалттай буюу тогтвортой түвшинд амьдрах даацтай байна. Монгол орны аль бус нутагт хүн амын суурьшлын даацын нөөц (нийт боломжит хүн амьдрах) ихтэй байна вэ?



- A. Зүүн бүс B. Баруун бүс C. Улаанбаатарын бүс D. Хангайн бүс
21. Хэрвээ танай нутагт доорх хоёр станцын нэгийг барихаар болсон бол алийг нь баривал давуу тал ихтэй вэ? Яагаад?







- A. Зураг-1, Яагаад гэвэл дулааны цахилгаан станц нь түүхий нүүрс, газрын тос, байгалийн хий ихээр түлж, дулаан ихээр ялгаруулах, зардал бага байдаг.
B. Зураг-2, Яагаад гэвэл усан цахилгаан станц нь агаарын бохирдол үүсгэхгүй, тогтмол эрчим хүч авах боломжтой, санхүүгийн хямралд өртдөггүй.
C. Зураг-2, Яагаад гэвэл усан цахилгаан станцыг барихад их хөрөнгө шаардлагатай, мөн их хэмжээний газар нутаг усанд автах эрсдэл өндөртэй.
D. Зураг-1, Яагаад гэвэл дулааны цахилгаан станц нь том газар нутгийг эрчим хүчээр хангадаг, нүүрс, газрын тос, байгалийн хий зэрэг түүхий эд ихтэй.

22. Монгол орны бэлчээрийн даац ашиглалтын мэдээллийг ашиглан 2020 оны мэдээллийг диаграммаар зөв илэрхийлсэнг сонгоорой.

Хүснэгт 1. Бэлчээрийн доройтлын ангиллын хувь

№	Бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал	2017 он	2018 он	2019 он	2020	2021
1	I-Байгалийн унаган төрхөө алдаагүй	30%	19%	17%	12%	12%
2	II - бага зэрэг доройтсон	55%	38%	35%	43%	45%
3	III - Дунд зэрэг доройтсон	12%	19%	22%	21%	18%
4	IV- Хүчтэй доройтсон	4%	20%	21%	18%	17%
5	V - Mash хүчтэй доройтсон	0%	4%	5%	6%	8%
Нийт хувь		100	100	100	100	100



23. Дорж гэр бүлийн хамтаар хөдөө гарч, Фермерийн аж ахуй эрхлэхээр болоход түүний эцэг эх нь харин уламжлалт аж ахуй эрхлэхийг санал болгожээ. Доржид туслан фермерийн аж ахуй эрхлэлтийн **давуу** талуудыг гаргаарай.

- А.Ажлын байр бий болгох, техник ашиглах учир эрчим хүч их шаардлагатай
- Б.Хүнсний хангамжийг бууруулах, мэргэжил боловсрол шаардлагатай
- С.Мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах, бэлчээрийн талхагдлаас сэргийлэх
- Д.Бэлчээрийн талхагдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө мөнгө их шаардлагатай

24. Мал аж ахуйн ашиг шим, өсгөх чиглэлийг 5 хошуу малтай зөв харгалзуулаарай.

- | | |
|----------|---|
| 1) Адуу | a. Ноос, арьс, махны чиглэлээр голлон өсгөнө |
| 2) Тэмээ | b. Ноолуур, мах, сүүний чиглэлээр голлон өсгөнө |
| 3) Ямаа | c. Сүү, эвэр, туурайн чиглэлээр голлон өсгөнө |
| 4) Хонь | d. Max, сүү, хялгасны чиглэлээр голлон өсгөнө |
| 5) Үхэр | e. Max, сүү, шир чиглэлээр голлон өсгөнө |
- A. 1в,2а,3б,4д,5г B. 1г,2д,3б,4а,5в C. 1г,2а,3д,4б,5в D. 1в,2д,3б,4а,5г

САНАМЖ



1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул зөв хариултыг олж тогтоож, харгалзах [a] үсгийн дагуу хариуг бөглөөрэй. Жишээлбэл: Зөв хариу 2-ыг сонгосон бол [a] дээр 2-ыг тоог будаж бөглөнэ.
2. Хэрэв бодлогын хариу бутархай тоо байвал бодлого тус бүрийн хариултын загварын дагуу бөглөнө. Жишээлбэл: Бодлогын хариу 45.67 гарсан гэж үзвэл тухайн бодлогын хариулт бөглөх загварыг [ab.cd] гэсэн байдлаар өгсөн байна. Дээрх хариу гэж бөглөхдөө a4 b5 c6 d7 гэж бөглөнө.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ЗАДГАЙ ДААЛГАВАР

2.1 Доорх өгөгдлийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй.

2021 оны I улирлын байдлаар 15, түүнээс дээш насны хүн амын 1,073,290 нь эдийн засгийн идэвхтэй хүн ам бөгөөд үүнээс хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 18290 байна.

АЖИЛЛАХ ХҮЧ. (2021 - I улирлын байдлаар)



i. Ажилтай иргэдийн тоо хамгийн бага байгаа хугацааг сонгоорой.

[a]

1. 2020-IV 2. 2020-III 3. 2019-II 4. 2019-IV

ii. Эдийн засгийн идэвхтэй хүн ам гэж юу вэ?

[b]

1. Нийт хүн амын 16-60 хүртэлх насны эрэгтэйчүүд, 16-55 насны эмэгтэйчүүд
2. Ажиллагсад болон хөдөлмөр халамжид бүртгэлтэй ажилгүй иргэдийн нийлбэр
3. Ажиллагсад болон эдийн засгийн идэвхтэй хүн амын тооны харьцаа
4. Ажилгүй иргэдийн тоо, эдийн зэсгийн идэвхтэй хүн ам хоёрын харьцаа

iii. 2021 оны 1-р улирлын байдлаар Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийн түвшин хэдэн хувьтай байгааг тооцоолоорой. (Бодлогын хариуг тооцоолоходоо аравны нарийвчлалтай бичээрэй)

[cd,e]

$$\text{Хэт} = \frac{\text{Ажиллагсдын тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн ам}} \times 100\%$$